



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/377

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 37 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, 4.1 дэх хэсэг, Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2026 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд багачуудыг монгол ёс зан заншил, нүүдэлчин ахуй, өв уламжлалаа өвлөн авах, сурч мэдэх, амьдрах ухаанд суралцуулах тэднийг хөгжил, оролцоогоор дамжуулан хамгаалах, хөгжүүлэх зорилгоор "Засагт ханы хот айл" гэр зуслангийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, сурталчилан таниулах үйл ажиллагаанд хөрөнгө гаргасугай.

2."Оюун сайхан соён гэгээрэл" Нийгэмд үйлчлэх Төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, шаардагдах 7,000,000 /долоон сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:zahiramjZax ZD 2026

8200010701

